



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 00 сарын 09 өдөр

Дугаар А/304

Арвайхээр

Нэг удаагийн буцалтгүй тусламж  
үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.6, Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арвайхээр сумын иргэн, чөлөөт бөхийн Олон улсын хэмжээний мастер Намдагдоржийн Эрхэмбаяр Бразил улсын Кашаис ду Сул (Caxias do Sul) хотод зохион байгуулагдсан зуны Дифлимкийн XXIV наадамд оролцож, алтан медаль хүртсэн тул цаашид спортын тэмцээн уралдаанд оролцох нөхцөл боломжийг бүрдүүлэх зорилгоор 10,000,000 (арван сая) төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж үзүүлсүгэй.

2. Дээрх 10,000,000 (арван сая) төгрөгийн зардлыг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Ганболд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6222 11 0651